



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 11 дүгээр сарын 04  
№ 43 (1241)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

776.	Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 146	3046
777.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 147	3046
778.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 148	3047
779.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 149	3047

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

780.	Техникийн зохицуулалт батлах тухай	Дугаар 205	3048
------	------------------------------------	------------	------

	• ᠑᠘᠑	• ᠑᠘᠑	• 7᠑᠘	• ᠗᠑᠘	
<b>ᠨᠠᠭᠠᠨᠠᠨ</b>	ᠮᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠨ	ᠮᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠨ	ᠮᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠨ	ᠮᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠨ	ᠮᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠨ
᠑᠙᠐᠓᠓	᠑᠙᠐᠓᠓	᠑᠙᠐᠓᠓	᠑᠙᠐᠓᠓	᠑᠙᠐᠓᠓	7᠙᠐᠓᠓



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар  
хот

### Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 186 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Нямдоогийн Баярмааг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Нямдоогийн Баярмааг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар  
хот

### Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Лхагвасүрэнгийн Ариунцэцэгийг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан



Лхагвасүрэнгийн Ариунцэцэгийг Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар  
хот

### **Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 220 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дашдоржийн Азжаргалыг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2. Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дашдоржийн Азжаргалыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар  
хот

### **Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай



хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нацагдоржийн Нямдавааг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2022 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар  
хот

### **Техникийн зохицуулалт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.“Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын техникийн зохицуулалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т тус тус үүрэг болгосугай.

3.Техникийн зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Б.БАТ-ЭРДЭНЭ**

Засгийн газрын 2022 оны 205 дугаар  
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

## **ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **Нэг.Ерөнхий зүйл**

#### **1.1.Зорилго, хамрах хүрээ**

1.1.1.Энэ зохицуулалт нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил, түүнд хэрэглэгдэх хими, биологийн бэлдмэлийн техникийн үзүүлэлт, шаардлагыг тогтооход оршино.

1.1.2.Энэ зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа, тэмцлийн ажил явуулдаг болон уг бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

#### **1.2.Норматив эшлэл**

Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараахь стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийг хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

-MNS 6532 Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6533 Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6535 Ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6537 Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6536 Ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6538 Ойн хөнөөлт шютте өвчинтэй химийн аргаар тэмцэхэд тавих шаардлага.



-MNS 6534 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага.

-MNS 6543 Хайрсан далавчтаны багийн хөнөөлт шавжтай тэмцэх “Bt-MN01” бактерийн биобэлдмэл. Техникийн шаардлага.

-MNS 6173 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх энтомотоксин бэлдмэл. Техникийн шаардлага.

-MNS 6479 Хөнөөлт шавжтай тэмцэх “Грийн” биобэлдмэл. Техникийн шаардлага.

-MNS 6480 Хөнөөлт шавжтай тэмцэх “Бассиана мускардин” биобэлдмэл. Техникийн шаардлага.

-MNS 6763 Шавж наалдуулагч цаасан урхи хэрэглэх арга.

-MNS 6724 Шавьж цуглуулах, боловсруулах, тодорхойлох, хадгалах арга.

-MNS 6458 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага.

-MNS 4992 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.

-MNS 4967 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томьёо, тодорхойлолт.

-MNS 5029 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.

-MNS 4978 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага.

### **1.3. Нэр томьёо, тодорхойлолт**

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“ой” гэж Ойн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

1.3.2.“ойг хамгаалах” гэж Ойн тухай хуулийн 3.1.9-д заасныг;



1.3.3. “ойн баялаг” гэж Ойн тухай хуулийн 3.1.11-д заасныг;

1.3.4. “ойн дагалт баялаг” гэж Ойн тухай хуулийн 3.1.12-т заасныг;

1.3.5. “ургамал хамгаалал” гэж Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.3-т заасныг;

1.3.6. “ургамлын өвчин” гэж Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.4-т заасныг;

1.3.7. “хөнөөлт шавж” гэж Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.5-д заасныг;

1.3.8. “ургамал хамгаалах бодис” гэж Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.8-д заасныг;

1.3.9. “тэмцэх арга хэмжээ” гэж Ургамал хамгааллын тухай хуулийн 4.3-т заасныг;

1.3.10. “пестицид” гэж Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.5-д заасныг;

1.3.11. “хүлцэх хэмжээ” гэж Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.9-д заасныг.

### **Хоёр. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавигдах шаардлага**

2.1. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил, түүнд хэрэглэгдэх хими, биологийн бэлдмэлд дараахь шаардлага тавигдана:

2.1.1. ой хамгааллын бодис, бэлдмэлийг турших, улсын бүртгэлд бүртгүүлэх, ашиглах, улсын бүртгэлээс хасахад байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан “Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам”-ыг мөрдөнө;

2.1.2. ой хамгаалах биологийн гаралтай бэлдмэлийг турших, бүртгэх, тэдгээрийг хэрэглэх, шаардлага хангахгүй бодисыг бүртгэлээс хасах, устгахад хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Ургамал хамгаалах биологийн гаралтай бодисыг турших, бүртгэх, тэдгээрийг хэрэглэх, бүртгэлээс хасах, устгах журам”-ыг мөрдөнө;





2.1.3. тухайн жилд шинэчлэн батлагдсан жагсаалтад орсон пестицид, биологийн бэлдмэлийг ашиглах болон ашиглахаар сонгосон пестицид, биологийн бэлдмэлийн техникийн үзүүлэлт, шаардлага нь жагсаалтад заасан үйлчлэх бодисын хувь хэмжээ, томьёо, олон улсын бүртгэлийн дугаар (CAS)-тай нийцсэн, туршилт хийсэн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаас батлан гаргасан зааврын дагуу хэрэглэнэ;

2.1.4. тухайн жилд байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан хөдөө аж ахуйд ашиглаж болох пестицидийн жагсаалтад тусгагдсан ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх химийн бэлдмэлийг ашиглана;

2.1.5. хөдөө аж ахуйн салбарт ургамал хамгаалал, хөрсний үржил шимийг сайжруулах зориулалтаар ашиглах биологийн гаралтай бодисын талаар мэргэжлийн санал, дүгнэлт гарах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлөөс тухайн жилд тогтоосон ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох бэлдмэлүүдийн жагсаалтад тусгагдсан биологийн бэлдмэлийг хэрэглэнэ;

2.1.6. ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын хими, биологийн бэлдмэл, сав, баглаа боодлын шошго, тээвэрлэх тээврийн хэрэгсэл, хадгалах агуулах, ажлын байрны анхааруулах тэмдэг зэрэг нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” MNS 5029 стандартын шаардлагыг хангасан байна;

2.1.7. ойн бүрэлдэхүүн, нас, өтгөрөл, ойн экологийн онцлог болон тухайн шавж, өвчний төрөл зүйлд тохирсон химийн бодисын тун хэмжээг байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран жил бүр шинэчлэн батална;

2.1.8. ойн бүрэлдэхүүн, нас, өтгөрөл, ойн экологийн онцлог болон тухайн шавж, өвчний төрөл зүйлд тохирсон биологийн бэлдмэлийн тун хэмжээг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгуулсан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн дүгнэлтээр тогтооно;

2.1.9. химийн бодис, биологийн бэлдмэлийг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр тавигдах шаардлага, нөхцөлийг хангаж хэрэглэнэ;

2.1.10.биологийн бэлдмэлийг ойд түгээмэл хөнөөл учруулдаг шавжтай тэмцэхэд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгуулсан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн дүгнэлтээр баталсан тун хэмжээгээр хэрэглэнэ;

2.1.11.химийн бодисыг ойд түгээмэл хөнөөл учруулдаг шавжтай тэмцэхэд байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран жил бүр шинэчлэн баталсан орц нормоор хэрэглэнэ;

2.1.12.биотехникийн арга хэмжээний хүрээнд ойн хөнөөлт шавжийн төрөл, зүйлд тохирсон фермонт урхийг судалгаа, тэмцлийн ажилд ашиглахад “Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6537 стандартын дагуу хэрэглэнэ;

2.1.13.ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6532 стандартыг нийтлэг байдлаар мөрдөх бөгөөд тэмцлийн аргаас хамаарч дараахь стандартын шаардлагыг мөрдөнө:

2.1.13.1.ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар тэмцэл явуулахад “Ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6535 стандартын шаардлагыг хангасан байх;

2.1.13.2.ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэхэд “Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6537 стандартын шаардлагыг хангасан байх;

2.1.13.3.ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэхэд “Ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6536 стандартын шаардлагыг хангасан байх;

2.1.13.4.ойн өвчинтэй химийн аргаар тэмцэхэд “Ойн хөнөөлт шютте өвчинтэй химийн аргаар тэмцэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 6538 стандартын шаардлагыг хангасан байх;

2.1.13.5.ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаа явуулахад “Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6533 стандартын шаардлагыг хангасан байх.

## 2.2.Хөдөлмөр хамгаалалд дараахь шаардлага тавигдана:

2.2.1.хөнөөлт шавж, өвчний судалгаа явуулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн эрх бүхий байгууллага байх бөгөөд ажилтан, албан хаагчдаа химийн бодис, биологийн бэлдмэлийн талаар анхан шатны мэдлэг олгох сургалтад хамруулна;

2.2.2.ажиллагсад ажил эхлэхээс өмнө эрүүл мэндийн эмнэлгийн үзлэгт хамрагдаж, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгтэй болсон байна;

2.2.3.химийн бодис, биологийн бэлдмэлтэй 18 нас хүрээгүй иргэд, хөхүүл, жирэмсэн эмэгтэйчүүд, харшил, мэдрэл, амьсгалын зам, арьсны өвчтэй хүн ажиллахыг хориглоно;

2.2.4.ажиллагсад хөдөлмөр хамгааллын хувцас, нүдний шил, амны хаалт, бээлий болон бусад хэрэгслээр хангагдсан байна;

2.2.5.тэмцлийн ажил өдөрт 6 цагаас илүүгүй хугацаагаар үргэлжилнэ;

2.2.6.ажиллагсдад сүү, тараг, жимсний шүүс, витамин зэрэг өөр тухайн бодисын үйлчлэлийг саармагжуулах шингэн зүйл олгоно;

2.2.7.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажиллагсдад өдөр бүр танилцуулж гарын үсэг зуруулна;

2.2.8.тэмцлийн ажилд ашиглагдах техник, багаж хэрэгсэлд өдөр тутам шалгалт хийж, бүрэн бүтэн байдалд хяналт тавина;

2.2.9.химийн бодис, биологийн бэлдмэлийн нэр төрөл тус бүрд албан ёсоор баталгаажсан тун, хэмжээ, технологийн зааврыг мөрдлөг болгож хяналтын бүртгэл хөтөлнө:

-Бэлдмэлийн худалдан борлуулалт, хэрэглээ, зарцуулалтын бүртгэл;

-Хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, ашиглалтын бүртгэл;

-Чанарын хяналтын бүртгэл;

-Буцаалт, устгалын бүртгэл;

-Хяналтын бүртгэлд он, сар, өдөр болон хэмжих нэгж зэргийг заавал тодорхой бичнэ.

2.3.Хорио цээрийн үйл ажиллагаанд дараахь шаардлага тавигдана:

2.3.1.тэмцлийн ажлын хорио цээрийг ажил гүйцэтгэх ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, ойн анги, нөхөрлөл, багийн Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид хамтран гүйцэтгэнэ;

2.3.2.тэмцэл явуулах газар нутагт тэмцэл явуулсан өдрөөс хойш ойд үйл ажиллагаа явуулах, мал бэлчээх, аялал зугаалга хийх, ойн дагалт баялаг түүх, зөгий бэлчээх хугацааг тодорхойлсон захирамжийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гаргаж хорио цээр тогтооно;

2.3.3.тэмцэл явуулах газар нутагт анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулна;

2.3.4.хорио цээр тогтоосон тухай тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим сүлжээгээр 3-аас доошгүй удаа зарлан мэдээлнэ;

2.3.5.тэмцэл явуулах ойн орчимд нутаглаж байгаа айл, өрхөд орон нутгийн олон нийтийн цахим сүлжээгээр хүрэх боломжгүй бол бичгээр мэдэгдэнэ;

2.3.6.механик аргаар тэмцлийн ажил гүйцэтгэх үед хорио цээр тогтоохгүй байж болно.

2.4.Хими, биологийн бэлдмэлийг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахад дараахь шаардлага тавигдана:

2.4.1.ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх химийн бодис, биологийн бэлдмэлийг хамгаалах, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахад “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 8, 10, 12, 13, 14 дүгээр зүйлийг тус тус мөрдөнө;

2.4.2.химийн бодис, биологийн бэлдмэлийн агуулах нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458 стандартын шаардлагыг мөрдөж ажиллана.



**Гурав.Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх  
ажлын тохирлын үнэлгээ, хяналт**

3.1.Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын үр дүнг “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6534 стандартыг баримтлан тооцно.

3.2.Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд хэрэглэх хими, биологийн бэлдмэлийн тохирлын үнэлгээг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13, 14, 15 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

3.3.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ авах зорилгоор хяналт-шинжилгээний сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

3.4.Хими, биологийн бэлдмэлийн үзүүлэлтийг тодорхойлох хэмжилт, шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийнэ.

3.5.Энэхүү техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

---o0o---

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**